


Хөтөлбөрт хамрагдах боломж

Хөтөлбөрт дараах хоёр чиглэлээр хамрагдах боломжтой. Үүнд:

1. Зээлийн гэрээ
2. Сургалтын гэрээ

Аль ч гэрээг байгуулсан тохиолдолд сургалтуудад хамрагдаж, швейцарь мэргэжилтнээс бизнес зөвлөгөө авна.

Хөтөлбөрт нэмүү өртөг шингээсэн бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ болон боловсруулах үйлдвэрүүд (газар тариалан, фермер, худалдаа наймааны салбараас бусад) оролцох боломжтой.



Хөтөлбөрт хэрхэн хамрагдах вэ?

- Бүртгэлийн хуудас бөглөх
- BPN-ийн ажилтнууд үйлдвэрлэлтэй очиж танилцах
- Бизнес төлөвлөгөө, санхүү бүртгэлийн сургалтад суух
- Бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлан, төлөвлөгөө боловсруулах, зөвлөгөө авах
- Швейцарь мэргэжилтэн зөвлөгөө өгч, ярилцлага хийх
- Хөтөлбөрт оролцох боломжтой эсэхийг шийдвэрлэх
- Гэрээ байгуулах

Манай хаяг



СБД, 8-р хороо, Оюутны 33

"ТАНАН" төв, 404 тоот

Утас: 70113309, 77113309

Э-шуудан: info@bpn.mn

Мэдээлэл өгөх цаг: Мягмар гариг бүрийн 10:00 цагт



BPN
Business Professionals Network



Монголын Үйлдвэрлэлийн Хөгжлийн Төлөө


Жижиг, дунд үйлдвэрийг
дэмжих хөтөлбөр



www.bpn.mn

Бидний тухай

БPN (Business Professionals Network) нь бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсад салбартай байгууллага юм. Манай эрхэм зорилго бизнес эрхлэгчдийг бизнесийн удирдлагын түвшинд чадавхижуулснаар ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино. Бид чадварлаг жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулж, үйл ажиллагаагаа мэргэжлийн түвшинд удирдан явуулж, амжилтад хүрэхэд нь дэмжлэг үзүүлдэг.



Зөвлөгөө

Бизнесээ зөв удирдах, хөгжүүлэхэд нь мэргэжлийн зөвлөгөө өгнө. Зөвлөгөө нь бизнес төлөвлөгөө боловсруулах, санхүүгийн хүснэгт гаргах, цаашлаад хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхээс эхлэнэ. Манай зөвлөхүүд бизнесээ амжилтад хүргэхэд тулгамддаг асуудал, хямралын үеийг даван гарахад туслахаас гадна мэргэжлийн түвшинд, шударга ажиллахад нь урам зориг өгдөг.



Бизнес академи

Хөтөлбөрийн оролцогч нь 2-4 жилийн хугацаанд бизнес академиас явуулж буй үндсэн дөрвөн сургалтууд болон нэмэлт сургалтуудад хамрагдаж, бизнесийн удирдлагын чиглэлээр суурь мэдлэг олж авна. Сургалт практикт тулгуурласан тул хэрэгжүүлэхэд хялбар, амжилтанд хүрэх боломжтой юм. Цаашид бизнес эрхлэгчдийн хэрэгцээг шаардлагад үндэслэн нэмэлт сургалт зохион байгуулна.

Үндсэн дөрвөн сургалтын товч агуулгыг хүснэгтээс харна уу.



Бизнесийн удирдлага

Бизнесийн удирдлагын гол гол хэрэгсэлтэй танилцаж, бизнес төлөвлөгөөгөө боловсронгуй болгохоос гадна хэрэгжүүлэх аргад суралцана. Мөн бизнесийн ёс зүйн талаар чухалчлан авч үздэг.

Санхүүгийн менежмент

Компанийн мөнгөн урсгал, тайлан, тооцоо, элэгдэл хорогдол зэрэг санхүүгийн үндсэн хэрэгсэлтэй танилцана. Компанийнхаа тайлан, төлөвлөгөөг харьцуулснаар үйл ажиллагаагаа оновчтой болгож, санхүүгээ хянах аргачлалыг олж авна.

Маркетинг

Сургалтаар хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох нь хэрхэн чухал болохыг олж мэднэ. Мөн маркетингийн үндсэн хэрэгслийг таниулж, компанийнхаа маркетингийн төлөвлөгөөг боловсруулна.

Хамт олноо удирдах

Аливаа компанийн гол баялаг нь ажиллагсад байдаг тул баг хамт олноо зөв, сайн удирдах нь амжилтын нэг гол хүчин зүйл юм. Бизнес эрхлэгч ажиллагсадтайгаа зөв харцаж, тэдний чадавхийг нээн илрүүлж, мэргэжил, ур чадварынх нь дагуу дэмжин ажиллахад суралцана.

Зээл

Бизнес эрхлэгч үйл ажиллагаандаа нийцсэн тоног төхөөрөмжийн зээл авч, зөв хөрөнгө оруулалт хийснээр бизнесээ амжилтанд хүргэх боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг манай вэб хуудаснаас авна уу.



Бизнес эрхлэгчдийн нийгэмлэг

Бизнес эрхлэгчид харилцан туршлага солилцох, хамтран шийдэлд хүрэх болон эрх ашгаа хамгаалах, өөрсдийн дуу хоолойг олон нийт, төр засгийн өмнө илэрхийлэхэд нийгэмлэгийн зорилго оршино. Нийгэмлэгийн хүрээнд нэмэлт сургалтуудад хамрагдаж, олон талт арга хэмжээ зохион байгуулах боломжтой. Үйл ажиллагаа амжилттай байх нь гишүүдийн идэвх санаачлага, оролцооноос ихээхэн хамаарна.

